# Дэлхийн ардчилсан залуучуудын байгууллагатай Зөвлөлтийн залуучууд Комсомолын найрсаг холбоо

Дэлхийн залуу үеийнхний улс төрийн өсөлтийн шинж чанар нь юуны өмнө социалист орнууд ба ЗХУ, хилийн чанад дахь залуучуудын үнэний тухай мэдэхээр тэмүүлж байна.

Капиталист орнуудын охид хөвгүүд шинэ социалист орнуудыг өөрсдийн нүдээр харахыг хүсцгээж байна. Орчин үед капиталист орнуудын залуучууд, оюутны ихэнх нь орос хэлийг судалж ЗХУКН—ын программтай танилцаж, ЗХУ-тай харилцах найрамдлын нийгэмлэгт гишүүнээр элсэж байна.

Сүүлийн жилүүдэд хилийн чанад дахь орнуудын залуучуудаас Зөвлөлтийн охид хөвгүүдийн хэрхэн яаж амьдарч сурч, ажиллаж хөдөлмөрлөж буйг сонирхох нь ер бусын ихээр өсч байна. Энэ нь ЗХУ-д хүрэлцэн ирж буй хилийн чанад дахь орнуудын залуучуудын төлөөлөгчдийн тооны өсөлтөөс харагдаж байна.

Жил бүр ЗХУ—д дэлхийн өнцөг булангаас олон мянган төлөөлөгчид, 10 мянган залуу тойрон аялагчид хүрэлцэн ирж байна.

Лениний Комсомол Зөвлөлтийн залуучууд одоо 100 гаруй орны залуучууд оюутны 1100 байгууллага мөн олон улсын залуучуудын олонхи байгууллагыг дэмжиж холбоотой ажиллаж байна.

Эдгээрийн дотор коммунист, зүүн социалист, радикал, консерватив, шашны болон гэгээрэл, соёл, биеийн тамир хүүхдийн зэрэг улс төрийн янз бүрийн чиглэлийн байгууллагууд орж байна.

Ардчилсан залуучуудын байгууллагууд энх тайвны төлөө, зэвсгийг бүрэн хураахын төлөө, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхийн эсрэг милитаризм ба хонзогногчдын эсрэг залуучуудын эрх, ардчиллын төлөө хамгийн тууштай тэмцлийг явуулж байна.

Ази, Африк, Латин Америкийн залуучуудын байгууллага олон улсын залуучуудын хөдөлгөөнд идэвхтэй үүргийг гүйцэтгэж байна. Эдгээр орнуудын ард түмнүүдийн үндэсний чөлөөлөх тэмцэл орчин үеийн агуу их хүч болж байна.

Колонийн дарлалын дор 20—30 жилийн өмнө 100 сая хүн байсан бол одоо хэдэн арван сая хүн үлджээ. Сүүлийн жилүүдэд хэдэн арван улсууд өөрийн үндэсний тусгаар тогтнолыг олж авлаа.

Эдгээр орнуудын залуучуудын байгууллага өөрийн ард түмнийхээ хамт шинэ амьдралын төлөө тэмцэж байна.

Залуучуудын улс төр, нийгэм эдийн засгийн эрх, ардчиллыг хангахын төлөө АНУ—ын монополийн эсрэг тусгаар тогтнолын төлөө тэмцэлд Латин Америкийн залуучуудын хөдөлгөөн улам идэвхжин хүчтэй болж байна. Латин Америкийн залуучуудын хөдөлгөөний үндсэн шинж нь империализмын эсрэг чиглэж үндэсээ нэгтгэхийг эрмэлзэж байгаа юм.

1960 онд Гаванд хуралдсан Латин Америкийн залуучуудын 1 дүгээр их хурал ба 1964 оны 3 дугаар сард Сант—яго (Чилийн) хуралдсан 2 дугаар их хурал үүнийг гэрчилж байна.

ЗХУ—ын коммунизмын байгуулалтын амжилт, социалист орнуудын социализмын байгуулалтын ололтууд нь Ази, Африк, Латин Америкийн орнуудын үндэсний чөлөөлөх хөдөлгөөний явцад нөлөөлөх чухал хүчин зүйл болж байна.

Зөвлөлтийн залуучуудын байгууллага нь эдгээр орнуудын олон тооны залуучууд оюутны байгууллагатай найрамдалт холбоо тогтоож, түүний үйл ажиллагааг дэмжиж байна. Тухайлбал: Конго (Бразавиль), Судан, Мила, Цейлон, Комбож, Гана, Чили гэх мэт бусад олон орны залуучуудын байгууллагыг дурьдаж болно. Нийгмийн дэвшилт үндэсний тусгаар тогтнолын төлөө империализмын эсрэг явуулж буй Ази, Африк, Латин Америкийн залуу үеийнхний тэмцэлд Зөвлөлтийн залуучууд идэвхтэй дэмжлэг үзүүлж байна. Олон улсын залуучуудын эв санааны нэгдлийн өдөр 4 дүгээр сарын 24-нийг Зөвлөлтийн залуучууд жил бүр өргөн тэмдэглэж байна.

Зөвлөлтийн залуучуудын байгууллага Ази, Африк, Латин Америкийн залуучуудын байгууллагад үзэл санаа болон эд материал эмнэлгийн ба биеийн тамирын хэрэглэл, ном илгээж туслаж байгаагаас гадна өөрийн залуу мэргэжилтнүүдээ тэнд ажиллуулахаар явуулж байна.

Сүүлийн жилүүдэд Зөвлөлтийн залуучууд Өмнөт Вьетнам, Цейлоны залуучуудын хаягаар эм, эмчилгээний зүйл, хагалгааны хэрэгслэл киноны төхөөрөмж, биеийн тамирын хэрэгслэл, мөн Калькут хотын оюутны эрүүлжүүлэх ордонд гэрлийн бүрэн төхөөрөмж, номын сан, дунд сургуулийн хичээлийн хэрэгслэлийг явуулсан байна.

Лениний Комсомол Кубын хөдөө аж ахуйд залуу боловсон хүчнийг бэлтгэхэд тусалж байна.

1961—64 онуудад Кубад Зөвлөлтийн 1000 гаруй залуу мэргэжилтнүүд очсон ба Кубаас ЗХУ—ын хөдөө аж ахуйд практик хийхээр хэдэн мянган залуу хүрэлцэн иржээ.

С. Цэнд «Спутник Комсомольского активиста» номноос орчуулав.

# ЗХУ—ын тогтмол хэвлэлээс

Манай уншигчид орос хэл дээр хэвлэгдэн гарах гэж буй ЗХУ—ын сонины төсөлтэй танилцах гэж байна. ЗХУ—ын сонинууд нь ЗХУ болон хилийн цаадахь орнуудын амьдралд болж буй чухал үйл явдлын тухай нийтлэн мэдээлэх болно. Эдгээр сонинууд нь Зөвлөлтийн ард түмний түүхэн богино хугацаанд, хоцрогдсон газар тариалангийн хаант Оросыг тэргүүний аж үйлдвэрийн гүрэн болгосон тухай ба коммунизмын байгуулалтын замаар замнаж яваа өөрийн орны агуу их ололт эдийн засаг, соёлын хөгжилтийн тухай өгүүлэх болно. Зөвлөлтийн сонинууд нь дэлхийд анх удаа үүсэн тогтносон ажилчин тариачны улсын амьдрал, уншигчдын сонирхсон янз бүрийн зүйлд хариулт өгөх болно.

ЗХУ—ын сонинуудыг уншицгаая!

1. ПРАВДА

Хэрэв та ЗХУ—ын улс төр, нийгэм соёлын амьдралын чухал үйл явдалтай танилцахыг хүсвэл өдөр бүр хэвлэгдэн гардаг ЗХУКН—ын Төв Хорооны хэвлэл «Правда»-г уншаарай.

Энэ сонинд намын амьдрал, үйл ажиллагааны тухай мэдээлж, ЗХУКН—ын ээлжийн их хурлын тухай хилийн чанадахь орнуудын коммунист намуудын их хурлын тухай болон ЗХУ-ын цахилгаан мэдээллийг нийтлэнэ.

Энд ЗХУКН—ын их бага хурал дээр ЗХУКН, Зөвлөлт засгийн газрын удирдагчдын хэлсэн үгийн бүрэн эх, орчин үеийн үндсэн асуудлын талаар Зөвлөлт засгийн газрын үзэл санаа энх тайвнаар зэрэгцэн орших, бүх нийтээрээ зэвсгийг бүрэн хураах асуудлаар ЗХУ—ын төрийн зүтгэлтнүүд хилийн чанадахь орнуудад албан ёсны айлчлалт хийсэн тухай хэвлэн нийтлэгдэнэ.

«Правда» сониныг уншигчид олон улсын чухал үйл явдлын тухай, хилийн чанадахь орнуудын дотоод байдлын тухай олон улсын сэтгүүлчдийн коллекторийг олж үзэх болно.

Зөвлөлт орны амьдралын тухай коммунист нийгмийн байгуулалтанд Зөвлөлтийн ард түмний олж буй ололт амжилтын тухай олон тооны өгүүлэл, материалууд тус сонинд хэвлэгдэх болно. Тус сонины хуудсанд техникийн дэвшилт, улс ардын аж ахуйн удирдлагыг цаашид улам сайжруулах төлөвлөгч байгууллагуудын асуудлыг хэлэлцэнэ.

«Правда» нь жилд 365 дугаар хэвлэгдэнэ.

2. ИЗВЕСТИЯ. СССР-ийн Дээд Зөвлөлийн хэвлэл «Известия» сонины хуудсанд ЗХУ—ын шинжлэх ухаан техникийн ололт, зөвлөлтийн хүмүүсийн бодит амьдралыг тусган харуулдаг.

Соёл шинжлэх ухаан, хөдөө аж ахуйн хөгжилт, аж үйлдвэр, тээврийн ажил зөвлөлүүдийн үйл ажиллагаа социалист ардчилалын хөгжлийн асуудалд зориулагдсан өгүүлэл сурвалжлага, тоймууд тус сонинд гол байрыг эзэлдэг юм.

Тус сонинд аж үйлдвэр, хамтрал сангийн аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт явцын тухай сурвалжлага, мэдээ, хот, тосгоны хөдөлмөрчдийн амьдралын тухай, хөдөлмөрчдийн үзэл санаа, ахуй амьдралын тухай ихээхэн анхаарал тавьж, өгүүлэл, найруулал байнга нийтэлдэг юм. «Хилийн чанад» хэсэгт дэлхийн өнцөг буланд болж буй үйл явдлаас товч мэдээлдэг.

Мөн олон улсын харилцаа түүний хөгжлийн үндсэн асуудлаар сонирхолтой албан мэдээг олж үзэж болно.

Тус сонин нь Зөвлөлт засгийн газрын албан баримт, ЗХУ—ын парламент бусад орнуудын харилцаа, түүний хөгжлийн тухай өгүүлнэ. Тус сонины хуудсанд биеийн тамир, шинэ киноны тухай байнга тойм нийтлэгдэнэ.

Иймч учраас тус сонинг Зөвлөлтийн болон хилийн чанадахь орнуудын уншигчид өргөнөөр ашигладаг юм. Жилд 300 дугаар хэвлэгдэнэ.

3. БХЛКЗЭ—ийн Төв Хорооны хэвлэл «КОМСОМОЛЬСКАЯ ПРАВДА.»

Энэ сонины хуудсанд комсомолын их хурлын материал, комсомолын анхан шатны байгууллагын бүх талын үйл ажиллагаа, манай охид, хөвгүүдийн амьдрал ахуй урлаг уран сайхан ажлын өсөлтийг тод томруун харуулсан өгүүлэл, уран зураг, хөгжлийн талаар сонины маргаан, залуу зохиолчдын яруу найраг, шинэ кино, жүжигтэй залуу үеийнхнийг танилцуулах ба капиталист орнуудын залуучуудын энх тайван эрх чөлөө, аз жаргалын төлөө тэмцэж буй тэмцлийг өгүүлнэ. Өөрийн болон хилийн чанадахь орнуудад явагдаж байгаа биеийн тамирын төрөл бүрийн тэмцээний тухай тэмдэглэл мэдээ, тогтмол нийтлэж байдаг.

Жилд 300 дугаар хэвлэгддэг.

4. БХҮЭ—ийн Төв Зөвлөлийн сонин «ТРУД» нь ЗХУ—ын хөдөлмөрчдийн баатарлаг үйлс шинээр байгуулагдаж буй хот, фабрик, завод, шинэ үйлдвэрүүдийн хүчин чадал үйлдвэрлэлд шинжлэх ухаан техникийн шинэ амжилт ололтуудыг нэвтрүүлж байгаа талаар өгүүлдэг юм.

Сонин нь ҮЭ—ийн байгууллагуудын ажил түүний их бага хурлуудын материал ДҮЭ—ийн холбооны үйл ажиллагаа, дэлхийн ажилчин ангийн нэгдэл нягтралыг бэхжүүлэхийн төлөө тэмцэж буй ажилчин ангийн тэмцэл, колоничлолыг устгах бүрэн мөсөн устгах өнө бат энх тайвны төлөө тэмцэл, олон улсын байдал, янз бүрийн орны хөдөлмөрчдийн амьдрал тэмцлийн тухай тойм, мэдээг байнга нийтэлдэг юм.

Жилд 300 дугаар гардаг.

5. ЗХУКН—ын Төв Хорооны хэвлэл «СОВЕТСКАЯ РОССИЯ» сонины хуудсанд олон улсын үйл амьдрал, гадаад орнуудад болж буй янз бүрийн үйл явдлаас ЗХУ болон гадаад орнуудад явагдаж буй томоохон тэнцээнүүд, ХОУ-ын зохиолчид, урлагийн зүтгэлтнүүдийн бүтээл урлаг уран сайхны талаар сонирхолтой өгүүлэлүүдийг нийтлэнэ. Жилд 300 дугаар гарна.

6. ХОУ—ын зохиолчдын 7 хоногийн сонин «ЛЕТРАТУРНАЯ РОССИЯ» нь орос ба Зөвлөлтийн алдарт яруу найрагч, зохиолч, жүжигчдийн гар бичмэлтэй уншигчдыг танилцуулна.

Зөвлөлтийн зохиолчдын семинар хурал түүний бүтээлийг нийтлэнэ. 1963 оноос хэвлэгдэж байна. Сонины хэмжээ 24 хуудастай жилд 52 дугаар гардаг.

## ЗХУ—ын сэтгүүлчдийн II хурал хуралдаж байна